



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 10
сарын 05 өдөр

Дугаар 289

Улаанбаатар
хот

Нехөрлөлийн гуанз ажил-
луулах тухай

Нийтийн хоолны үйлчилгээг өргөтгөх, хөдөлмөрийн нөөцийг оновчтой ашиглах, хөдөлмөрийн нехөрлөлийн гишүүдийн хүчийг дээрх ажилд чиглүүлэн зохион байгуулах зорилгоор хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

НЭГ. Сүхбаатарын районы нийтийн хоолны трестийн харьяа "Янгир" кафе, зайдасны цагт нехөрлөлийн гуанзыг 1987 оны 10 дугаар сард багтаан нээж, нийтийн үйлчилгээнд зориулан ажиллуулахыг Хөдөлмөр нехөрлөлийн товчоо /н.Цоомоо/-нд даалгасуучай.

ХОЁР. Нехөрлөлийн гуанз нээж ажиллуулахтай холбогдуулан "Янгир" кафе, зайдасны цэгийн байруудыг 1987 оны 10 дугаар сарын 1-нээр хөдөлмөр нехөрлөлийн товчоонд шилжүүлж егөхийг Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т уураг болгосугай.

ГУРАВ. Хөдөлмөр нехөрлөлийн товчоо /н.Цоомоо/-нд даалгах нь:

~~Хотын АДХ-ын~~ 1. Нехөрлөлийн гуанзыг ажиллуулах журмыг боловсруулж мөрдөн ажилласугай.

2. Нийтийн хоолны удирдах газраас шилжин очиж байгаа "Янгир" кафе, зайдасны цэгийн байрыг гуанз гарган ажиллуулах нехөрлөдд олгож 2 жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулсугай.

3. Авто тээврийн 30 дугаар баазын цайны газарт ажиллаж байгаа нехөрлөлийн гуанзыг нийтэд үйлчлүүлж, хөдөлмөрийн гэрээтэй ажиллуулсугай.

4. Тэтгэврийн буюу хөдөлмөрийн насын ажил, мэргэжлийн чадвартай хотын иргэдийг тадний саналын үндсэн дээр нехөрлөдд элсүүлж байх.

5. Хөдөлмөрийн насын буюу гадаадын харьяат иргэдийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны холбогдох газар, хэлтсийн зөвшөөрөлтэйгээр ажиллуулж байхаар тогтоосугай.

6. Хотын нийтийн хоолны удирдах газраас гуанзны нехөрлөдд шилжүүлэн егч байгаа барилгуудын заслын ажилд шаардагдах хөрөнгийг нехөрлөлийн гишүүдээс гаргуулж, засварын ажлыг нь хийж егех, засварын ажилд шаардагдах материалыг олж нийлүүлэхэд туслашцаа узуулж ажилласугай.

7. Нехөрлөлийн гуанзны барилга түүний тоног төхөөрөмж, тавилга хэрэгслэлийн элэгдэл хорогдлын шимтгэлийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 395 дугаар тогтоод заасан хувиар, Нийтийн хоолны удирдах газарт дулаан, цахилгаан, цэвэр бохир усны үнийг тогтоогдсон тарифын дагуу холбогдох

ашиглалтын байгууллагуудад аж ахуйн гэрээний дагуу гуанзны нехерлелүүдээр төлүүлж байсугай.

8. Нехерлелийн гуанзуудыг "Нехерлелийн гуанз № " гэсэн тодорхой хаяг адрестай болгон ажиллуулахыг даалгасугай.

9. Нехерлелийн гуанзуудыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангуулж, хотын нийтийн хоолны удирдах газрын хэмжээнд мөрдөгдөж байгаа үйлчилгээний бусад дурэм зааврыг мөрдүүлж ажиллуулсугай.

10. Аж ахуйн гэрээний уураг, ариун цэврийн дурмийг зөрчиж, хөдөлмерийн сахилга, ажлын хариуцлага алдсан нехерлелийн гишүүдэд захирагааны арга хэмжээ авч байсугай.

11. Нехерлелийн гуанзнаас улсад оруулах орлогыг түүний олсон цэвэр ашгийн 10 хувиар тооцдог журам тогтоосугай.

12. Нехерлелийн гуанзны хэрэгцээнд зориулан дэлгүүр, мухлаг, сангийн аж ахуй, хүнсний зах, арц иргэд, албан байгууллагуудын туслах аж ахуйгаас шаардлагдах хүнсний материалыг тохиролцооны үнээр бэлнээр худалдан авч хангаж ажилласугай.

ДӨРӨВ. Хотын төлөвлөгөөний комисс /н.Дугаржав/-т даалгах нь:

1. Сүхбаатарын районы нийтийн хоолны трестийн зарим цэг салбар, хөдөлмөр нехерлелийн товчоонд шилжсэнтэй холбогдуулан тус трестийн 1987 оны IV улирлын төлөвлөгөөнд зохицуулалт хийх.

2. Нехерлелийн гуанзны ажиллагааг дэмжих зорилгоор эдгээр хоолны газруудад хэрэглэх махны 30 хүртэл хувь, гурил болон бусад материалыудыг хэрэгцээт хэмжээгээр нь гуанз байгуулагдсанаас хойш I жилийн хугацаанд жижиглэн худалдаалах үнээр хотын фондоос олгож байсугай.

ТАБ. Нехерлелийн гуанз нээсэнтэй холбогдуулж тэдний хүснэгтээр банкны зээлийг нэг жилийн хугацаатайгаар зохих журмын дагуу /нэг нехерлэлд 50,0 мянга хүртэл төгрөг/ олгож байхыг Хотын банкны контор /н. Цэрэндорж/-т зөвшөөрсүгэй.

Зургаа. Нийтийн үйлчилгээний гуанз нээж ажиллаж байгаа нехерлелүүдэд даалгах нь:


1. Нехерлелийн гуанзанд хотын нийтийн хоолны удирдах газрын хэмжээгээр мөрдөгдөж байгаа ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг бүрэн билүүлж, үйлчилгээний ажилтай холбогдсон дурэм зааврыг мөрдэж, хөдөлмерчдийн эрэлт хэрэгцээ, санал хүсэлтийг байнга авч, хөнгөн шуурхай, соёлч байдлаар үйлчилж байсугай.

2. Хоолны үнийг нехерлэл өөрсдөө тогтоож, талонгуйгээр үйлчилж байхыг зөвшөөрсүгэй.

3.

3. Нехөрлөлийн гишүүдээс түр хугацаагаар өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдахад олгох цалин хэлс буюу шагнал урамшилын хэмжээг нөхөрлөл дотроо хэлэлцэн тогтоож орлогоосоо гаргаж байсугай.

ДОЛ00. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авч ажил мэргэжлийн туслалцаа үзүүлж эзхион байгуулахыг Худалдааны хэлтэс /н.Сүхээ/, Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс /н.Зул/-т уураг болгосугай.



УДААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮҮДЭГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

УДААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮҮДЭГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-
ЛАГАТАЙ НАРИИН БЧГИЙН ДАРГА

Д.АЛГИА

Барынж